

ТУСГАЙ БҮЛГИЙН ХҮҮХДИЙН ХӨГЖМИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ БАГШИЙН
ДААЛГАВАР

Даалгавар:№ 1	Сургалтын чиглэл: Хөгжим
Илрүүлэх чадвар: Дууны үгийг багшийг даган хэлж, аялан дуулна.	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	“Хамтдаа дуулая”	
Хэрэглэгдэхүүн	Багш сургалтаар заасан дуугаа сонгон авч тохирох хэрэглэгдэхүүн материалыг бэлдсэн байна. Даралтад болон төгөлдөр хуур хөгжмийг хэрэглэнэ.	
Даалгаврын заавар	Багш хөгжмөө тоглон дууг биечлэн дуулж үзүүлнэ. Үгийг зөв тод хэлнэ. Багштайгаа хамтдаа дуугаа зэрэг дуулна. Дууны 1-р бадгийг дуулна.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	<ul style="list-style-type: none"> - Багш нь дуу дуулж өгье. анхааралтай сонсоорой - Чи энэ дууг мэдэх үү? - Дуунд юу юу гарч байна вэ? хэлээрэй - Багштайгаа хамтдаа дууны үгийг хэлээрэй - Хамтдаа дуугаа дуулаарай. <p>Багш дасгалын төгсгөлд багштай хамт тоглосон чамд баярлалаа. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гэж хэлээд алга ташна.</p>	<p>Багш хөгжим тоглож дууг биечлэн дуулна.</p> <p>Дуунд гарсан зүйлийн тухай ярилцана.</p> <p>Багш хөгжмийг тоглож хүүхэдтэй хамтдаа дуулна. Хүүхэд дууг зөв тод хэлж аянд даган дуулж байгааг ажиглана.</p>
Дэмжлэг	Хүүхэд тогтож сонсож чадахгүй байгаа бол дууг нэг удаа дуулж өгч болно.	
Анхаарах зүйл	<ul style="list-style-type: none"> - Багш өөрийн заасан дуунаас сонгоно. - Хүүхдийн анхаарал сарнихгүй тав тухтай орчин бүрдүүлнэ. - Тухайн хүүхдийг бэлэн болтол хүлээнэ. 	

ТУСГАЙ БҮЛГИЙН ХҮҮХДИЙН ХӨГЖМИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ БАГШИЙН
ДААЛГАВАР

Даалгавар: №2	Сургалтын чиглэл: хөгжим
Илрүүлэх чадвар: Хэмнэл сонсож тоглох	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	“Хэмнэлээр наадаг”	
Хэрэглэгдэхүүн	Бөмбөрөөр тоглох хэмнэлийн дасгалын бичлэг	
Даалгаврын заавар	Багш бөмбөрөөр хэмнэлийг тоглож сонсоно. Хүүхэд сонсож мэдэрсэнээ тоглож илэрхийлнэ.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	<ul style="list-style-type: none"> - Багш нь чамд нэг хөгжим өгье. - Барьж тэмтрээд үзээрэй ямар хөгжим байна вэ? - Багшийгаа 1 гэж хэлэхэд баруун гараараа бөмбөрөө 1 удаа цохиорой - Багшийгаа 2 гэж хэлэхэд зүүн гараараа бөмбөрөө 1 удаа цохиорой - Өөрөө тоглоорой. - Багш дасгалын төгсгөлд багштай хамт тоглосон чамд баярлалаа. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гэж хэлээд алга ташна. 	<p>Багш хэмнэлийг бөмбөрөөр тоглож сонсоно. Бөмбөрийг хүүхдийг гарт бариулна. Бөмбөрийг хүүхэдтэй хамт тоглоно.</p>
Дэмжлэг	Багш хүүхдийг ажиглан идэвхгүй байвал дэмжлэг үзүүлнэ.	
Анхаарах зүйл	Хүүхдийг даалгавар авах сургалтын өрөөнд оруулж сандал дээр суулгана. Ингэхдээ орж байгаа орчинг урьдчилан хэлж тайлбарлаж өгнө.	

ТУСГАЙ БҮЛГИЙН ХҮҮХДИЙН ХӨГЖМИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ БАГШИЙН
ДААЛГАВАР

Даалгавар:№ 3	Сургалтын чиглэл: Хөгжим
Илрүүлэх чадвар: Хүүхэд багшийг даган дуурайж хөдөлгөөн хийнэ.	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	“Амьтад болж тоглоё” хөгжимт хөдөлгөөн	
Хэрэглэгдэхүүн	Туулай, баавгайн дохионы хэлний зурагт үзүүлэнг багш бэлдсэн байна.	
Даалгаврын заавар	Багшийн заасан туулай,баавгайн хөдөлгөөнийг дохиогоор илэрхийлэн хөдөлгөөн хийнэ.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	Ширээн дээр байгаа амьтдын зургаас туулайн дүрсийг сонгон аваарай. Багшийгаа дагаад туулай болж үсрээрэй. Баавгайн хөдөлгөөнийг даган дуурайж хийгээрэй. Багш дасгалын төгсгөлд багштай хамт тоглосон чамд баярлалаа. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гэж хэлээд алга ташна.	Хүүхэд багшийг даган дуурайна.
Дэмжлэг	Даалгаврыг ойлгоогүй хүүхдэд дахин тайлбарлаж өгнө.	
Анхаарах зүйл	Үйлдлийг хийхэд хүүхдийг яаруулахгүй байна.	

ТУСГАЙ БҮЛГИЙН ХҮҮХДИЙН ХӨГЖМИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ БАГШИЙН
ДААЛГАВАР

Даалгавар: №4	Сургалтын чиглэл: Хөгжим
Илрүүлэх чадвар: Дууны ая сонсоод сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	А гоёо гоё	
Хэрэглэгдэхүүн	Хүүхдийн мэддэг дуу болон аялгууны бичлэгийг сонгоно. Тоглуулагч	
Даалгаврын заавар	Дууны хоолойтой бичлэгийг сонгоно. Багш өөрөө биечлэн хөдөлгөөнийг хийж дуулж үзүүлнэ. Хүүхдүүд даган дуурайн хийнэ Хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийхийг оролдоно.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	-Багш нь нэг дуу сонсгоё. -Дууны аялгуунд багш нь үг хэлж хөдөлгөөн хийнэ. -Анхааралтай хараарай. -Багшийгаа дагаад хамтдаа хөдөлгөөнөө хийцгээе. -Багш дасгалын төгсгөлд багштай хамт тоглосон чамд баярлалаа. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гэж хэлээд алга ташна.	Дууны бичлэг бэлтгэсэн байна. Дууны аянд тохирсон хөдөлгөөн хийнэ. Хүүхдийг магтаж урамшуулна.
Дэмжлэг	Багш хамтдаа дахин нэг удаа хөдөлгөөнийг хийнэ. Хүүхдийг ажиглан идэвхгүй байвал дэмжлэг үзүүлнэ.	
Анхаарах зүйл	Хүүхдийн дуу болон хөгжмийн аяыг багш өөрөө сонгоно. Үйлдлийг хийхэд яаруулахгүй байна. Хүүхдийн анхаарал төвлөрөлт, харилцаа үүссэний дараа даалгаварыг гүйцэтгэнэ. Хүүхэд бухимдалтай байвал тайвширтал хүлээнэ.	



ТУСГАЙ БҮЛГИЙН ХҮҮХДИЙН ХӨГЖМИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ БАГШИЙН
ДААЛГАВАР

Даалгавар:№5	Сургалтын чиглэл: Хөгжим
Илрүүлэх чадвар: Шагшуур хөгжмийг дуугаргаж тоглох	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	“Шагшуураар наадая”.	
Хэрэглэгдэхүүн	Төрөл бүрийн шагшуур энгийн хөгжмийн зэмсэг	
Даалгаврын заавар	Багш өөрөө хөдөлгөөнийг хүүхдүүдэд биечлэн дуулж үзүүлнэ. Дүрст бичлэгийг ажиглуулна. Багшийг дагаж хөдөлгөөнийг хийнэ. Хэмнэлд тохируулан дасгалыг хамтдаа хийнэ.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	Багш нь нэг бичлэг үзүүлье. - Анхааралтай хараарай. - Энэ ямар хөгжмийн зэмсэг вэ? - Хүн бүр 1ш шагшуур аваарай. - Дасгалын хэмнэлийг анхааралтай сонсоорой ямар өөрчлөлт гарч байна вэ? - Хамтдаа хэмнэлээ зэрэг тоглоорой. Хөгжмөө сэгсэрч дуугаргаарай. Багш дасгалын төгсгөлд багштай хамт тоглосон чамд баярлалаа. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гэж хэлээд алга ташна.	Багш шагшуур хөгжмийг дуугаргаж сонгоно. Хүүхдийг дэмжиж урамшуулна.
Дэмжлэг	Хүүхдэд шагшуур бариулж, сэгсэрч дуугаргахад нь тусална.	
Анхаарах зүйл	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн гарт барихад эвтэйхэн шагшуур хөгжмийг сонгох - Хүүхдэд тохирсон сандлыг сонгож зөв байрлалд суулгах - Хөгжмийг хэт чанга дуугаргахаас болгоомжлоорой 	

ТУСГАЙ БҮЛГИЙН ХҮҮХДИЙН ХӨГЖМИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ БАГШИЙН
ДААЛГАВАР

Даалгавар:№ 6	Сургалтын чиглэл: Хөгжим
Илрүүлэх чадвар: Хэмнэл тоглох	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	“Алга ташъя”	
Хэрэглэгдэхүүн	Хэмнэлийг харуулсан зурагт карт, Хэмнэлийн дасгалын дүрст бичлэг	
Даалгаврын заавар	Багш хэмнэлийн зурагт картыг ажиглуулан ярилцана. Хэмнэлийн дасгалыг 1-р хэсгийг үзүүлж хэмнэлийг ажиглуулна. 2-р хэсгээс дасгалын дагуу хамтдаа хийнэ. Бичлэгийг ажиглуулна. Хэмнэлийн дасгалыг хийхдээ найз нөхдөө сонсож зэрэг хийхийг хэлнэ.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	<p>- Хэмнэлийн дасгалын зураг байна. Сайн ажиглаарай. -Ямар ямар хэмнэл байна вэ? -Зургийг хараад хийгээд үзээрэй. -Багш нь хэмнэлийн дасгалын бичлэгийг үзүүлэе. Хэмнэлийн дасгалын дагуу хэмнэлд тохируулан дагуу хийгээрэй</p>   <p>Багш дасгалын төгсгөлд багштай хамт тоглосон чамд баярлалаа. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гэж хэлээд алга ташна.</p>	<p>Хэмнэлийн дасгалын зургийн дагуу хүүхдүүдийг бие даан хийлгэнэ. Зургийг хараад ойлгохгүй байгаа тохиолдолд багш тайлбарлаж өгнө.</p>
Дэмжлэг	Хэмнэлийг жигд хийхэд нь дэмжлэг үзүүлэх, хөгжмийн аянд алга таших оролдлого хийж байхад нь урамшуулна. Даалгаврыг эхлэхээс өмнө багш биечлэн нэг удаа хэмнэлийг тоглож үзүүлнэ.	
Анхаарах зүйл	Хэмнэл тоглох зурагт үзүүлэн ойлгомжтой байх, хүүхдийн анхаарал сарнихгүй орчинг бүрдүүлэх, даалгавар гүйцэтгэх зааврыг дохионы хэлээр ойлгомжтой тайлбарлаж өгөх.	

ТУСГАЙ БҮЛГИЙН ХҮҮХДИЙН ХӨГЖМИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ БАГШИЙН
ДААЛГАВАР

Даалгавар:№7	Сургалтын чиглэл: Хөгжим
Илрүүлэх чадвар: Хүүхэд багшийн хөдөлгөөнийг даган дуурайн хамт хөдөлгөөн хийж дуулах	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	“Хамтдаа дуулцгаая”	
Хэрэглэгдэхүүн	Багш сургалтын агуулгын хүрээнд заасан дууг сонгон авна. Шаардлагатай хэрэглэгдэхүүнийг сонгоно.	
Даалгаврын заавар	Багш өөрөө дууг биечлэн дуулж үзүүлнэ. Үгийг дагуулан хэлнэ. Багштайгаа хамтдаа дуугаа дуулна. Дууны 1-2 бадгийг дуулна.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	Багш нь нэг дуу сонгоё. Анхааралтай сонсоорой. Дуунд ямар ямар дүр гарч байна вэ бэ? Багш дууны үгийг аялгуулан хэлнэ. Багштайгаа хамтдаа 1-р бадгийг дуулна. 2-р бадгийг үргэлжлүүлэн хамтдаа дуугаа дуулаарай. Багш дасгалын төгсгөлд багштай хамт тоглосон чамд баярлалаа. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гэж хэлээд алга ташна.	Дууны хоолойтой бичлэгийг сонгоно. Багш өөрөө хөгжмөө тоглож дуулж сонгоно.
Дэмжлэг	Дууг мэдэхгүй байгаа хүүхдэд дүрст бичлэгийг дагуулан дуулуулж болно.	
Анхаарах зүйл	Хүүхдийн анхаарал төвлөрөлт, харилцаа үүссэний дараа даалгавар гүйцэтгэнэ.	

ТУСГАЙ БҮЛГИЙН ХҮҮХДИЙН ХӨГЖМИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ БАГШИЙН
ДААЛГАВАР

Даалгавар №8	Сургалтын чиглэл: Хөгжим
Илрүүлэх чадвар: Амьтдын дууг сонсоод даган дуурайх	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа:Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	“Энэ ямар амьтан бэ?”	
Хэрэглэгдэхүүн	Хүүхдийн хамгийн сайн мэддэг амьтан болон заасан амьтдаас 2-г сонгож шум бичлэг бэлдэнэ. (Нохой, муур...), Амьтдын зурган карт	
Даалгаврын заавар	Багш ширээн дээр зурган картыг байрлуулсан байна. Бичлэгийг нэг нэгээр нь сонгоно. Хүүхэд сонссон амьтны зургийг сонгосны дараа дараагийн бичлэгийг сонгоно.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	-Багш нь чамд нэг амьтны дуу сонсоё. -Ямар амьтан дуугарсан бэ ? -Дуурайж дуугараарай. -Багш дасгалын төгсгөлд багштай хамт тоглосон чамд баярлалаа. -Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гэж хэлээд алга ташна.	Амьтны шум бичлэгийг сонгоно. Харилцан ярилцана. Хүүхэд амьтдын дуу чимээг сонсохыг оролдож байгаа, зургийг заахыг оролдож байгаа эсэхийг ажиглаж тэмдэглэнэ. Хүүхдийг дэмжиж урамшуулна
Дэмжлэг	Хүүхэд эргэлзсэн тохиолдолд дөхүүлсэн асуултыг тавиарай. Хүүхэд буруу хариулт өгсөн тохиолдолд зөв дуу чимээг дахин сонгоно .	
Анхаарах зүйл	Хүүхдийн анхаарал саринуулах үйлдэл болон чимээ гарсан тохиолдолд дахин сонгоно. Дараагийн дуу чимээг сонгохын өмнө анхааруулах үгсийг хэлнэ.	